



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 29 өдөр

Дугаар А/103

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.9 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн Хурдан морины айргийн 5 морины хашаа барих, сэрвээ хэмжилтийн багаж худалдан авах ажлын гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Д.Очирхуяг (Сум дундын Ойн ангийн дарга)


Гишүүд: Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)

Ц.Маргад-Эрдэнэ (Засаг даргын тамгын газрын нярав)

2.Захиалагчийн техникийн тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг хянан үзэж, гэрээний шаардлагыг биелүүлсэн нөхцөлд акт үйлдэж хүлээн авч танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Д.Очирхуяг)-д даалгасугай.

3.Хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэж, ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН